

ГАРЧИГ

ОРШИЛ	3
1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	4
1.1. Төслийн товч тодорхойлолт	4
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	8
3. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ	10
3.1. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл, бууруулах арга хэмжээ	10
3.2. Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл.....	10
3.3. Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	10
3.4. Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	10
4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫН ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	13
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	13
6. НӨХӨН СЭРГЭЭЛТ, ТЭР БУМ МОДНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ	16
7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ	17
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	18
9. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	18
10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	19
11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	21
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	24
13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	28
14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ СУМ БАГИЙН ИРГЭДЭД ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХУВААРЬ	29

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Төслийн талбайн солбицол	4
Хүснэгт 2. Ил уурхайн үндсэн хэмжээс	6
Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	14
Хүснэгт 4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	16
Хүснэгт 5. Тэр бум модны төлөвлөгөө	16
Хүснэгт 6. Дүйцүүлэн хамгаалах ажил	17
Хүснэгт 7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	20
Хүснэгт 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	22
Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	25
Хүснэгт 10. 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	28
Хүснэгт 11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь	29
Хүснэгт 12. 2025оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт	30

ОРШИЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь ордын үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм, журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч

“Баянгол тариалан” ХХК-аас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм.

Тус төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний үндсэн зорилго нь төслийг хэрэгжүүлэх явцад үүсэх бүхий л сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитоор төлөвлөх, улмаар энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлэх юм.

БОМТ боловсруулах аргачлал:

Тус төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчин, ногоон хөгжлийн яамны сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт холбогдох байгууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

“Баянгол тариалан” ХХК-ийн “Баянголын дэнж Б” хэсэг алтны шороон ордын БОМТ-нд 2026 онд нийт 42.6 сая төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-009495 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Баянголын дэнжийн Б хэсэг”-ийн алтны шороон ордын 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1.Төслийн товч тодорхойлолт

MV-009495 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь М-48-126 хавтгайд Төв аймгийн Заамар сумын нутагт Туул голын зүүн эрэг дагуу байрлана. Ашигт малтмалын газрын даргын 2010 оны 127 тоот тушаалын дагуу ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайн солбицлыг WGS- 84 тогтолцоонд албан ёсоор хөрвүүлж талбайн хэмжээг дахин тооцож 65.99 га гэж тогтоосон.

Хүснэгт 1. Төслийн талбайн солбицол

№	Уртраг	Өргөрөг
1	104° 30' 40.0"	48° 22' 0.0"
2	104° 30' 56.6"	48° 22' 0.0"
3	104° 30' 56.6"	48° 21' 50.0"
4	104° 31' 17.0"	48° 21' 50.0"
5	104° 30' 40.0"	48° 22' 0.0"
6	104° 30' 56.6"	48° 22' 0.0"
7	104° 30' 56.6"	48° 21' 50.0"
8	104° 31' 17.0"	48° 21' 50.0"
9	104° 30' 40.0"	48° 22' 0.0"
10	104° 30' 56.6"	48° 22' 0.0"
11	104° 30' 56.6"	48° 21' 50.0"
12	104° 31' 17.0"	48° 21' 50.0"
13	104° 30' 40.0"	48° 22' 0.0"
14	104° 30' 56.6"	48° 22' 0.0"
15	104° 30' 56.6"	48° 21' 50.0"
16	104° 31' 17.0"	48° 21' 50.0"
17	104° 30' 40.0"	48° 22' 0.0"
18	104° 30' 56.6"	48° 22' 0.0"
19	104° 30' 56.6"	48° 21' 50.0"
20	104° 30' 40.0"	48° 21' 32.0"
21	104° 30' 40.0"	48° 22' 0.0"
22	104° 30' 56.6"	48° 22' 0.0"
23	104° 30' 56.6"	48° 21' 50.0"
24	104° 31' 17.0"	48° 21' 50.0"
25	104° 30' 56.6"	48° 22' 0.0"
26	104° 30' 56.6"	48° 21' 50.0"
27	104° 31' 17.0"	48° 21' 50.0"

Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-009495 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Баянголын дэнжийн Б хэсэг”-ийн алтны шороон ордын 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр



Зураг 1. Талбайн байршлын тойм зураг

2026 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨЛТ

Уулын ажлын горим

2026 онд уулын ажил жилд 4 сар үргэлжлэх ба үйлдвэрлэлийн үндсэн процессууд нь тасралтгүйгээр өдөрт 1 ээлжээр 10 цагаар үргэлжилнэ. Үйлдвэрлэлийн бусад ажил болох цахилгаан хангамж, усан хангамж, гэрэлтүүлэг, баяжуулах тоног төхөөрөмж угсарч монтажлах ажлуудыг үйлдвэрлэлийн дотоод ажлын зохион байгуулалтаар хийнэ. Уурхайн ажиллах горимыг захиалагч байгууллагын техникийн даалгавар, уурхайн жилийн хүчин чадалтай нь уялдуулан дараах байдлаар сонгов.

Ашиглалтын систем

2026 онд ордын геологийн тогтоц, хөрсний чулуулгийн шинж чанар, олборлолтын арга, механикжуулалтын бүтэц, тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт зэргийг харгалзан өмнө нь ашиглаж ирсэн экскаватор-автосамосвалын хослол бүхий автотээвэртэй, дотоод овоолготой ашиглалтын системээр ашиглана.

Ил уурхайд ажиллах экскаватор болон автосамосвалын техникийн үзүүлэлтүүд, хөрс болон элсний давхраасын зузаанаас шалтгаалан ил уурхайн үндсэн хэмжээсүүдийг дараах байдлаар загварчиллаа.

Хүснэгт 2. Ил уурхайн үндсэн хэмжээс

№	Үзүүлэлт	Утга
1	Хөрсний доголын өндөр, м	0.4
2	Элсний доголын өндөр, м	3.6
3	Ажлын доголын хажуугийн налуу, град	50
4	Автозамын өргөн, м	10
5	Замын налуу, ‰	80
6	Ажлын талбайн өргөн, м	20-30

Уурхайн нээлт

Ордын нээлтийг одоогоор үүссэн байгаа элс угаах нуурын дэргэдээс буюу 1-р овоолгоос, Х-464129, Y-5358281 координатаас эхэлнэ. Нээлтийн ажлаар 14 хоногийн нөөц буюу 8.5 мян.м3 элс олборлон овоолгод хураана. Ашиглалтын явцад уулын ажил явагдахаар төлөвлөгдсөн талбайн өнгөн хөрсийг Монгол улсад дагаж мөрддөг шаардлага стандартын дагуу 0.3 м зузаантайгаар урьдчилан хуулна. Хуулж бэлтгэсэн шимт хөрс нь ордын ашиглалтын явцад болон ордыг ашиглаж дууссаны дараах нөхөн сэргээлт ажилд ашиглагдах юм. Шимт хөрсний овоолгын өндөр нь 1.5 м байх бөгөөд хажуугийн тогтворжилтын өнцөг нь 25-33 градус байна. Шимт хөрсийг хуурай сэрүүний улиралд хуулах нь тохиромжтой бөгөөд овоолгыг аль болох нөмөр газар хийх ба тийм боломжтэй тохиолдолд шимт хөрсний овоолгыг сууж дагтарштал нь тусгай зориулалтын торон хучилт хийж салхи шуурганд хийсэхээс сэргийлэх болон ургамалжуулж болно. Шимт хөрсийг уурхайн үндсэн хөрс хуулалтын ажлаас өмнө хуулж овоолсон байна. Ил уурхайн ашиглалтын хугацаанд 50.3 мян.м3 шимт хөрс хуулж овоолгод байршуулахаар байна.

Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-009495 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Баянголын дэнжийн Б хэсэг”-ийн алтны шороон ордын 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Уулын ажлын календарчилсан төлөвлөлт

Баянголын дэнжийн алтны үүсмэл шороон ордыг захиалагч компанийн ажлын даалгаврын дагуу эхний жилд 90.0 мян.м3 2 дахь жилд 117.9 мян.м3 элс олборлох хүчин чадалтайгаар 2 жилд ашиглахаар тусгалаа. Овоолго тус бүрээр авч үзвэл ашиглалтын 1-р жилд буюу 2026 онд бэлтгэл болон уурхай байгууламжийн ажлууд хийгдэх 1 ба 2 р овоолгыг ашиглана. Харин 2-р жилд буюу 2027 онд 2-5-р овоолгыг тус тус олборлохоор тус тус тусгалаа. Овоолгууд нь хуулах хөрс болон уул техникийн нөхцөлийн хувьд ижил болно.

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Уур амьсгал ус зүй: Хамгийн том гол нь Орхон голын баруун цутгал болох 600 км-ын урттай 1-4 км өргөн хөндий бүхий Туул гол юм. Голдирол тохойрол, тахирлалт ихтэй олон тооны хар ус, жижиг аралтай бөгөөд гульдралын өргөн нь 30-100 м, гүн нь 0.5-1.6 м зарим газраа 2.5 м хүрдэг. Урсгалын хурд 0.3-11 м/сек, хөндийн хэвгий нь 0.001-0.002, гульдралын үнэмлэхүй өндөр нь ордын хэмжээнд доод хэсэгтээ 900 м, дээд хэсэгтээ 960 м хөндийн татамын хэсэгтээ талархаг юм. Туул голын баруун талаас Цагаан булгийн гол цутгадаг ба түүний голдирол өргөн нь 1-3 м, гүн нь 0.2-0,5 м байдаг. Туул гол голдирол нь тусгай зөвшөөрөлт талбайн баруун захаас баруун тийш 400-500м-т зайтай урсах ба Цагаан булгийн горхи нь талбайн хойд хилээс хойш 100м зайтай урсан өнгөрдөг

Техникийн болон ахуйн хэрэгцээний усыг хөрсний усаар болон Туул голоос, харин ундны усыг уурхайн тосгоны ойролцоо орших өрөмдмөл худгийн газрын доорх усаар хангана. Газрын доорх ус агуулсан үе нь 6-30 м-ийн гүнд орших ба ойролцоогоор 3 л/сек ундаргатай байдаг.

Цаг агаарын хувьд эх газрын эрс тэс уур амьсгалтай, жилийн дундаж хэм нь +2.8°C байдаг. Хамгийн хүйтэн сар нь 1-р сар ба агаарын хэм нь -37°C, хамгийн дулаан сар нь 7-р сар ба агаарын хэм нь +40 С хүрдэг. Жилийн дундаж хур тунадасны хэмжээ 367.3 мм-ээс хэтэрдэггүй ба үүний 80% нь зуны улиралд бороо байдлаар ордог. Жилийн дундаж хур тунадасны хэмжээ 367 мм-ээс хэтэрдэггүй ба үүний 80% нь зуны улиралд бороо байдлаар ордог. Өвөл нь 5-25 см цасан бүрхүүл тогтож улирлын хөлдөлтийн гүн 2.5 м хүрдэг ба голчлон баруун өмнөөс 5-10 м/сек салхи салхилдаг. Заримдаа 20 м/сек хүрэх удаа бий. Туул гол 10-р сарын сүүлчээр хөлдөж эхлэх ба 4-р сарын эхээр гэсч эхэлдэг.

Хүн ам , эдийн засаг , дэд бүтэц: Хүн амын суурьшил нягт ба голчлон газар тариалан ба мал аж ахуй эрхэлдэг, халх ястан голлон амьдардаг ба Заамар сумын хэмжээнд 3000 орчим хүн амтай. Тус район нь зам харилцаа сайтай өвөл, зуны аль ч улиралд бартаа саадгүй, аж үйлдвэр, ХАА-н үйлдвэрлэлийн баазуудад ойр байрлана. Тухайлбал Хөтлийн цементийн үйлдвэрээс 180км, Дархан хотоос 200 км-т, Улаанбаатар хотоос 240 км-т оршдог.

Мөн газар тариалан, мал аж ахуй эрхэлдэг Бүрэгхангай сум 60 км, Заамар сум 42 км-т байдаг. Хамгийн ойр суурин газар нь ордоос баруун урагш 15км зайд орших “Шижир алт”, “Алтандорнод Монгол” компаниудын уурхайн Өгөөмөр тосгон юм. Энд ХААн банкны салбар, шуудан холбоо, Мобикомын станц, худалдаа үйлчилгээний газрууд байрладаг. Үүний зэрэгцээгээр одоо Туул голын хөндийд Заамарын бүлэг ордыг (Туулын, Баянголын, Тосонгийн драгийн полигон гэх мэт) ашигладаг олон үйлдвэр уурхай бий.

Ордоос урагш 27 км-т Улаанбаатар-Булганыг холбосон автомашины сайжруулсан зам, Туул голын бетонон гүүр, “Петровис” “МТ” компаниудын ШТСууд байдаг. Цахилгаан хангамж сайн. Улаанбаатар Эрдэнэтийн 220 квт өндөр хүчдэлийн шугам, түүнээс салаалан татсан

Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-009495 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Баянголын дэнжийн Б хэсэг”-ийн алтны шороон ордын 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Цагаанбулагийн 110 кВт-н цахилгаан дамжуулах агаарын шугамын туслах станц ордоос 4 км хүрэхгүй зайд байрлана.

Талбайн орчимд “Илт гоулд” ХХК-ын 6квт-ын өндөр хүчдэлийн шугам байхаас гадна талбайн баруун жигүүрээр “Монполимет” ХХК-ын 35квт-н шугам дайран өнгөрдөг. Мөн талбайн аль ч хэсэгт хөдөлгөөнт холбооны Мобиком, Ж-мобайль сүлжээний байнгын ажиллагаатай байдаг учир дэд бүтэц сайн хөгжсөн районд тооцогдоно.

3. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

3.1.Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл, бууруулах арга хэмжээ

2026 онд уулын ажлын хөрс хуулалт, элс олборлолт, овоолго, тээвэрлэлтийн үед тоосжилт үүсэж агаарыг бохирдуулахаар байна. Дотоод шаталтат хөдөлгүүрээс гарах утаа тортог агаар орчинд хэсэгчилсэн бохирдолтыг бий болгоно.

3.2.Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Түлш шатахуун, шатах тослох материалууд асгарах зэргээс үүдэн газрын болон газрын доорх ус бохирдох эрсдэлтэй. Ахуйн хатуу болон шингэн хог хаягдлын асуудлаа зөв менежментийн дагуу явуулаагүйгээс болж газрын гадарга болон гүний ус биологийн болон химийн бохирдолд орох эрсдэлтэй.

3.3.Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

2026 онд уурхайн хөрс хуулалт болон уурхайн дэд бүтцийн үйл ажиллагаанаас газрын гадаргын төрх байдал алдагдаж, хөрсөн бүрхэвч доройтож, ургамлан нөмрөг хөрсөнд дарагдах зэргээр эвдрэлд орно. Төслийн нутаг дэвсгэр болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэр дэх тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн доройтох, ургамлан нөмрөг тоосонд дарагдаж тачир сийрэг болж бүрхэц багасна. Ил уурхайн малталт, дотоод замууд, барилгын ажлууд зэрэг үйл ажиллагаанаас гарах сийрэг бүтэцтэй хөрс салхинд амархан хийсэж тоосжилт үүсгэнэ. Газрын гадарга болон хөрс ахуйн хаягдал, шатах тослох материалаар бохирдоно.

3.4.Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Уулын ажлын үед ашиглагдах техник тоног төхөөрөмжөөс гарах дуу чимээнээс болж хөхтөн, шувуу, жижиг мэрэгч амьтад дайжиж алга болох, машин механизм, тээврийн хэрэгслийн гэрэлтүүлгээс болж шөнийн амьдралтай амьтад үргэн дайжиж болзошгүй.

3.5.Нөхөн сэргээж буй газрыг хүн мал, салхи, усны нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах

Уурхайн эвдэрсэн газарт биологийн нөхөн сэргээлтийг бүрэн хийж дууссан газрыг бусад хүчин зүйлээс болж буцаж эвдэрч, доройтохоос хамгаалахын тулд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1. Хүн малын нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах

Биологийн нөхөн сэргээлт хийсэн газарт мал орох, болон санаатайгаар малаа хариулах, тарьсан мод, бутыг хэрэглэх, машин техникээр дээгүүр нь явах, ахуйн зорилгоор ухаж сэндийлэх зэрэг хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх шаардлагатай бөгөөд энд орон нутгийн захиргаа болон нутгийн иргэдийн ухамсарт оролцоо маш чухал үүрэгтэй байна.

2. Усны нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах

Нөхөн сэргээлт хийсэн газар нь хэвгий, налуу ихтэй хөрсний бүтэц султай болон бүтэцгүй тохиолдолд хөрс усаар угаагдаж, алдагдахаас сэргийлэх арга хэмжээ авах хэрэгтэй. Ийм газарт

ургамлын тарих эгнээг налуугийн эсрэг чиглэлд хийх, шигүү тарих, сахлаг үндэстэй ургамал тарих зэрэг арга хэмжээг авна.

3. Салхины нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах

Уурхай орчмын нутаг нь хуурай хээрийн бүсэд хамаарах газар учраас жилд тохиолдох хүчтэй салхи шуурганы давтамж өндөр байдаг. Иймээс биологийн нөхөн сэргээлт хийсэн газрыг салхины эвдрэл болон элсний нүүлтээс хамгаалах арга хэмжээг зайлшгүй шаардлагатай. Энд салхины зонхилох чиглэлд хөндлөн байдлаар бут сөөг модлог ургамал оролцсон зурвас байгуулах, төрөл бүрийн механик хамгаалалт хийх шаардлагатай.

Байгаль орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмж

Сөрөг нөлөөллийг бууруулах талаар дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Тоосжилт болон агаар бохирдуулагч хийнүүдийн хэмжилт судалгааг тогтмол хийж, хяналт тавих. Стандарт шаардлагад заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй байх арга хэмжээ авах.
- Хөрс хуулж овоолго хийх ажлыг аль болох цөөн хоногт багтаахаар зохион байгуулах.
- Тоосжилт тархах хүрээ ачиж, тээвэрлэх, буулгах газраас 50-100 м орчимд байхаар зам, овоолгын байршлыг оновчтой сонгох, улмаар байнгын ажлын байрнаас зайдуу байршуулах хэрэгтэй.
- Уурхайн дотоод тээвэрлэлтийн авто замуудыг байнга усалж байх, ялангуяа тоосжилт, шороон шуурганы гаралт нэмэгддэг хуурайшилттай хаврын улиралд төслийн талбайг усаар норгох, чийглэх
- Төслийн талбайн хэмжээнд олон салаа зам гаргахгүй байх, хөрс тээвэрлэсэн автомашиныг хучиж, хөрс, тоос салхинд хийсэж, агаар орчинд тархахаас урьдчилан сэргийлэх.
- Техник тоног төхөөрөмжийн үзлэг, шалгалтыг тогтмол явуулж, засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж гүйцэтгэх.
- Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт, овоолгыг стандартын дагуу хийх
- Ашиглалтын явцад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг тогтсон нэг маршрутын дагуу явуулах, МУ-ын стандартын дагуу замын уулзвар, салаалалт дээр тэмдэгжүүлэх
- Үржил шимт өнгөн хөрсийг хуулж овоолго хийх ажлыг аль болох цөөн хоногт багтаахаар зохион байгуулах
- Уурхайн үйл ажиллагааны явцад боломжтой газруудад нөхөн сэргээлтийг дор дор нь хийж байх
- Үржил шимт хөрсний алдагдал, өгөршлийг бууруулахын тулд хөрсний овоолгыг ургамалжуулах, шимт хөрсийг аль болох богино хугацаанд нөхөн сэргээлтэд ашиглах
- Ахуйн хаягдал усаар гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдуулахгүй байх арга хэмжээг авч ажиллах
- Тосгон ба ордыг хаврын шар усны болон хур борооны үерээс хамгаалах арга хэмжээ авах
- Тоног төхөөрөмжийн шатах тослох материал болон барилгын материалын Төвлөрсөн цэгийг байгуулж, нэвчүүлэхгүй материал ашиглан тохижуулах

Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-009495 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Баянголын дэнжийн Б хэсэг”-ийн алтны шороон ордын 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

- Талбайн хэмжээнд байрлах уст цэгүүдэд тогтмол горимын болон чанарын хяналт шинжилгээг явуулах
- Барилга, байгууламж байршуулсан хэсэгт үерийн ус зайлуулах шуудуу татах
- Шатах тослох материал, алдагдах, асгарах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах
- Уурхайн дотоод, гадаад тээврийн үйл ажиллагаанаас үүсэх орчны тоосжилтыг бууруулахад газар доорх усны нөөцийг ашиглахаас аль болох зайлсхийж, цэвэршүүлсэн ахуйн хаягдал усыг эргүүлж ашиглах боломжийг судлах, боломжтой бол ашиглах
- Тоосны ялгаралтыг зөвшөөрөгдөх хэмжээнд байлгахын тулд байнгын хяналттай ажиллах зэрэг арга хэмжээг авч ажиллана

Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-009495 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Баянголын дэнжийн Б хэсэг”-ийн алтны шороон ордын 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫН ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Тус орд нь шимт хөрсөө хуулаад элсний давхаргын таазанд хүрнэ. Иймд уурхайн амсрыг тойрсон нийт 50.3 мян.м³ эзлэхүүнтэй шимт хөрсний овоолго, угаан баяжуулах хэсгийн дэргэд 7-10 хоногийн нөөцтэй 8.0 мян.м³ элсний овоолго тус тус үүснэ. Ашиглалтын хугацаанд нийт 207.8 мян.м³ элс олборлох бөгөөд ашиглалтын явцад хуулах хөрс болон эфель, гаалийг дотоод овоолгод, ухашийн нөхөн дүүргэлтэд ашиглана.

Уурхайн нөхөн сэргээлт

2026 онд техникийн нөхөн сэргээлт 2.6 га талбайн дотоод овоолгоор нөхөн сэргээлт хийхээр төлөвлөж байгаа бөгөөд биологийн нөхөн сэргээлт хийгдэхгүй.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дээр дурдсан болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм. Болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг нөлөөлөлд өртөж болзошгүй бүрэлдэхүүн тус бүрээр нь ангилан тодорхойлов.

Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Засгийн газар, БОУАӨЯ болон бусад холбогдох газруудаас гаргасан зохих заавар, журмын дагуу “БАЯНГОЛ ТАРИАЛАН” ХХК-ийн “Баянголын дэнжийн Б хэсэг”-ийн алтны шороон ордын 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулав. Төсөл хэрэгжүүлэгч “БАЯНГОЛ ТАРИАЛАН” ХХК нь байгалийн баялгийг ашиглаж, үйл ажиллагааны сөрөг нөлөөллөө байгальд үзүүлж байгаагийн хувьд оршин буй нутгийн байгаль орчныг хамгаалахад үйл ажиллагааныхаа нэг хэсгийг чиглүүлэх ёстой.

Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-009495 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Баянголын дэнжийн Б хэсэг”-ийн алтны шороон ордын 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Агаарын чанар					
Уурхайн олборлолт, тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас тоосжилт үүсэх	Уурхайн олборлолт, хөрсний овоолго үүсгэх, түр шороон замаар тээвэрлэлт хийх үед усалгаа хийх,	Уурхайн ухаш, хөрсний овоолго, зам	2.0	2026 он	- Агаарын тухай хууль - Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль - MNS 4585:2016 - MNS 3384:82 MNS 4885:2007
	Тээврийн хэрэгсэлд хурдны хязгаарлалтыг 20 км/цагаар мөрдүүлэн ажиллах, хурдны хязгаарлалтын тэмдэг, тэмдэглэгээг байршуулах.	Төслийн талбайд	2.0		
Уулын ажлаас тоос босож орчны агаарын чанарыг муутгаад зогсохгүй уурхайд ажиллаж буй ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө	Уурхайд ажиллаж байгаа машин техникийн кабин доторх агааржуулах төхөөрөмж, хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хаалга, цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг тогтмол хийж, зөрчил илэрсэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авч бүхээгт тоос орохгүй болгох арга хэмжээ авч байх	Уурхайн бүх авто машинуудад	1.0	2026 он	
Уурхайн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтыг хянах	Агаарын хяналт шинжилгээг тогтмол хийх	Төслийн нөлөөллийн талбайд	Зардал нь ОХШХ-ийн зардалд орсон	2026 он	Агаарын тухай хууль
Нийт зардал			5.0		
Ус					
Усны нөөц, ашиглалт, усны бохирдол үүсэх	Ус ашиглалтын хяналтын дүн мэдээг жил бүр Усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж ус ашиглах дүгнэлтийг жил бүр шинэчлэх.	1	Үйл ажиллагааны зардалд орсон	Усны тухай хууль	
	Шатахуун, тос тосолгооны материал болон ахуйн хатуу шингэн хаягдлаар гадаргын болон газрын доорх ус бохирдохоос сэргийлэх	1	Үйл ажиллагааны зардалд орсон		
	Уст цэгүүдэд тогтмол хяналт шинжилгээ хийх		ОХШХ-ийн зардалд орно		
Нийт зардал			-		

Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-009495 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Баянголын дэнжийн Б хэсэг”-ийн алтны шороон ордын 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Амьтан					
Төслийн үйл ажиллагаанаас амьтдын амьдрах орчныг удаан хугацаагаар хомсдуулах зэргээр сөрөг нөлөө үзүүлнэ	Лицензийн талбайн бүс рүү зэрлэг амьтад орохыг хязгаарлах, хяналт тавих	Төслийн талбай түүний ойролцоо	Зардал нь ОХШХ-ийн зардалд орсон	Жил бүр	- Амьтны тухай хууль - Байгаль орчныг хамгаалах тухай
	Өвчилсөн, гамшигт, аюулт үзэгдэлд нэрвэгдсэн амьтанд тусламж үзүүлэх, авран хамгаалах.				
	Нэн ховор, ховор амьтныг хамгаалах.				
Нийт зардал			0.5		
Газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг					
Хөрс хуулах, элс олборлох, овоолго байгуулах явцад ургамал талхлагдан хөрс эвдрэлд орж, газрын тогтоц, хэлбэр, төрх өөрчлөгдөж, ухагдаж эвдэрнэ.	Хог хаях, шатах тослох материал асгах, хөрсний бохирдол үүсгэхээс сэргийлэх, олон салаа зам гаргахгүй байх талаар жолооч операторуудад сургалт явуулах	Бүх жолооч нарт	0.5	2026 он	MNS 5916:2008 MNS 5917:2008 MNS 5918:2023
Олон салаа зам гарснаас хөрсөн бүрхэвчийн элэгдэл, эвдрэлийн эрчим нэмэгдэнэ.	Уурхайн дотоод болон гадаад тээврийн замын дагуу шаардлагатай газруудад тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Осол аваар гарч болзошгүй цэгүүд	0.5	2026 он	
Биологийн нөхөн сэргээлтийн ажлын үр дүн шимт хөрсний чанараас хамаарна. Шимт хөрсний чанар муу байх нь нөхөн сэргээлтийн ажлыг үр дүнгүй болгож экосистемд сөрөг нөлөөлөл үзүүлнэ.	Шимт хөрснийг стандартын дагуу овоолж, ургамалжуулан хадгалах	50.3 мян.м3 шимт хөрс	3.0	2026 он	MNS 5916:2008
Нийт			4.0		
Нийт зардал, сая.төг			9.5		

Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-009495 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Баянголын дэнжийн Б хэсэг”-ийн алтны шороон ордын 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

6. НӨХӨН СЭРГЭЭЛТ, ТЭР БУМ МОДНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Нөхөн сэргээлтийн ажлын техникийн үе шатанд орд газрыг ашиглаж дууссаны дараа хөрсний овоолгыг хэвгийжүүлж, ухаж эвдэрсэн боломжтой газруудад дүүргэлт хийх, хэлбэршүүлэх, талбайг засаж тэгшлэх, бэлтгэсэн талбайг биологийн нөхөн сэргээлт хийхэд зориулж шимт хөрсөөр хучих зэрэг үйл ажиллагаа хамаарна.

Хүснэгт 4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Зорилт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7
1.	Техникийн нөхөн сэргээлт /Дотоод овоолго/	га	2.6	-	3000000		MNS 5914:2008 MNS 5918:2008 MNS5918:2008 MNS 4919:2000 MNS 4920:2000
2.	Биологийн нөхөн сэргээлт	-	-	-	-		
	Нийт	5000000					

Хүснэгт 5. Тэр бум модны төлөвлөгөө

№	Зорилт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7
3.	2025 онд Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд сум орон нутгийн саналын дагуу мод тарина	ш	100000	-	6000000	2026 онд	“Тэр бум мод” Үндэсний хөтөлбөрийн хүрээнд
	Нийт	6000000					

Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-009495 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Баянголын дэнжийн Б хэсэг”-ийн алтны шороон ордын 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

2025 онд дүйцүүлэх хамгаалах ажлаар орон нутгийн саналын дагуу хамтран ажиллана.

Хүснэгт 6. Дүйцүүлэн хамгаалах ажил

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
1.	Орон нутгийн саналын дагуу	-	3.0 га	-	-	10000000	2026 онд	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
	Нийт					10000000		

Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-009495 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Баянголын дэнжийн Б хэсэг”-ийн алтны шороон ордын 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбайд айл өрх, өвөлжөө хаваржаа байхгүй бөгөөд нүүлгэх шилжүүлэх ажил хийгдэхгүй болно.

9. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Баянгол тариалан ” ХХК-ийн “Баянголын дэнжийн Б” хэсгийн алтны шороон ордын талбай түүний ойр орчимд археологийн хүрээлэн болон палеонтологийн хүрээлэнгээр авран хамгаалах хайгуулын судалгааг хийлгэсэн бөгөөд ашиглалтад ямар нэгэн дурсгалт зүйл өртөхгүй. Шинээр түүх соёлын дурсгалт зүйл илэрвэл ажлаа зогсоож энэ тухай Заамар сумын ЗДТГ, цагдаагийн байгууллага болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ. Болзошгүй зардал 1000000 төг төсөвлөсөн.

10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БАЙГАЛИЙН АЮУЛ, ГАМШИГ

Аянга цахилгаан: Дулааны улиралд тохиолдох бөгөөд цаг агаарын мэдээг тогтмол мэдээлэх хэрэгтэй. Цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг стандартын дагуу газардуулсан байх, ил задгай цахилгааны утас зэрэг аянга үүсэж болзошгүй зүйлүүдийг хамгаалах

Газар хөдлөлт: Газар хөдлөлтийн мужлалаар төсөл хэрэгжих газар нь 6 баллын бүсэд хамаарна. Иймээс барилга байгууламж барихдаа зураг төслийн дагуу эрсдэлийг нарийвчлан авч үзэх шаардлагатай. Мөн ашиглалтын явцад газар хөдлөлтийн үед авах арга хэмжээг боловсруулах. Салхины хурдыг багасгах хаах тоос шороог багасгах зорилгоор салхины зонхилох чиглэлд ногоон байгууламжуудыг бий болгох. Уурхайн замыг тогтмол арчилж, усалгаа хийж чийгшүүлж байх. Ажлын байрны эрүүл ахуйн хяналтыг системийг бийболгох. Онц байдалд үйл ажиллагааг зогсоох тухай журам боловсруулж мөрдөх.

Шороон шуурга: Салхины хурдыг багасгах хаах тоос шороог багасгах зорилгоор салхины зонхилох чиглэлд ногоон байгууламжуудыг бий болгох. Уурхайн замыг тогтмол арчилж, усалгаа хийж чийгшүүлж байх. Ажлын байрны эрүүл ахуйн хяналтыг системийг бийболгох. Онц байдалд үйл ажиллагааг зогсоох тухай журам боловсруулж мөрдөх Халдварт өвчин: Уурхайн ажилчдад хууль бус ан агнахгүй байх түүнээс үүдэн гарах сөрөг нөлөөллийн талаар сургалт явуулах, хамгаалалтын хэрэгслээр хангах (амны хаалт г.м), аймгийн эрүүл мэндийн төвтэй харилцаа холбоотой байж мэдээлэл авч байх

Гал түймэр: Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, зааварчилгаа, хяналтын ажил, гал гарсан үед түүнийг унтраах хэрэгслийн хангамж, цахилгаан тоног төхөөрөмж дээр ажиллах үд мөрдөх аюулгүй ажиллагааны урьдчилан сэргийлэх арга хэмжээг МУ-н “Галын аюулгүй байдлын тухай хууль”, “Аж ахуй нэгж байгууллагад дагаж мөрдөх галын аюулгүй байдлын дүрэм”, “Гал түймрийн аюулгүй байдалтай холбогдуулан гаргасан тушаал, шийдвэрийн дагуу зохион явуулна

Авто тээврийн осол: Машин техникийн засвар үйлчилгээг тогтмол хийх, ажлын байрны үзлэг шалгалтыг байнга хийх. Ажилчдын аюулгүй ажиллагааны сургалтад тогтмол хамруулах. Уурхайн зам тээвэрт хурдны хязгаар тогтоож, тэмдэг тэмдэглэгээг сайн хийх, замын хөдөлгөөний аюулгүй дүрмийг чанд баримтлан ажиллах

Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-009495 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Баянголын дэнжийн Б хэсэг”-ийн алтны шороон ордын 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Үйлдвэрийн аваар осол, саатал гэмтлээс шалтгаалан ажилчид бэртэж гэмтэх, хөдөлмөрийн чадвараа алдах эрсдэлтэй,	Хөдөлмөр эрхлэлтийн явцад гарч болзошгүй осол бэртэл, өвчлөлийн жагсаалт гаргаж түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийн зөвлөмжийг боловсруулж ажилчдын хүртээл болгох	Тусгай зөвшөөрлийн талбайн хүрээнд	-	-	500000	Төслийн бүх хугацаанд	Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухайхууль
2	Ажилчдын аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч ажиллах	Ажлын өдөр эхлэх бүрд зааварчилгаа өгөх	Тусгай зөвшөөрлийн талбайн хүрээнд	-	-	-	Төслийн бүх хугацаанд	Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухайхууль
3	Ажлын байран дээрх осол эрсдэлээс сэргийлж ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгт хамруулах	Компани	-	-	Дотоод үйл ажиллагааны зардал	Төслийн бүх хугацаанд	Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухайхууль
4	Ажлын байран дээрх осол эрсдэлээс сэргийлж хөдөлмөр хамгааллын багаж хэрэгслээр хангах		Тусгай зөвшөөрлийн талбайн хүрээнд	-	-	1000000	Төслийн бүх хугацаанд	Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухайхууль
5	Уурхайн эмнэлгийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	Анхны түргэн тусламжийн багаж, эмээр хангах	Тусгай зөвшөөрлийн талбайн хүрээнд	-	-	500000	Төслийн бүх хугацаанд	Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухайхууль
	Нийт					1 000 000		

11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төслийн үйл ажиллагааны хүрээнд бий болох хаягдлыг авч үзвэл, ахуйн хатуу хог хаягдал, уурхайн хотхоны хэрэгцээнээс хаягдах бохир ус (хоолны газар, усанд орох газар, ариун цэврийн өрөө гэх мэтээс), үйлдвэрийн техникийн үйл ажиллагаанаас үүсэх хаягдал ус, техникт ашигласан хаягдал тос, маслын хаягдал зэргээс бүрдэж байна.

Тэдгээр хатуу, шингэн хаягдлыг хадгалах, зайлуулах тус бүлэг тусгасан болно. Хог хаягдлын менежмент нь хүний эрүүл мэндийг хамгаалах, ажилчид, нутгийн оршин суугчдын ажиллаж амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчинд дам үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн болно.

Хүснэгт 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	
Хог хаягдлаар хөрс бохирдох	Хог хаягдал ангилан ялгаж хаях зориулалттай хогийн савнуудыг тосгон, захиргаа, цайны газар зэрэг шаардлагатай газруудад тавих	2.0	Жил бүр	Хог хаягдлын тухай хууль
	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж түр хадгалах зориулалтын хогийн бункер байрлуулах	1.0	Тухай бүрд нь	
Төслийн үйл ажиллагаанаас үүсэх ахуйн хатуу болон шингэн хог хаягдлаар хөрс, гадаргын болон газрын доорх ус бохирдуулах сөрөг нөлөөтэй	Хуванцар сав, шил, лааз гэх мэт хаягдлыг сумын төвд 2-догч түүхий эд авах цэгт тушаах	-	Сард 1 удаа	4-р зүйл, 5-р зүйл 9-р зүйл, 11-р зүйл, 12-р зүйл, 13-р зүйл, 14-р зүйл, 16-р зүйл, 18-р зүйл, 19-р зүйл, 20-р зүйл, 21-р зүйл, 23-р зүйл, 24-р зүйл
	Дугуйн хаягдлыг дахин ашиглах байгууллагатай гэрээлэн нийлүүлэх	-	Тухай бүрд нь	
	Автомашинь сэлбэг, төмрийн хаягдлыг мэргэжлийн байгууллагад гэрээний дагуу нийлүүлэх	-	Жилд 2 удаа	
	Цаас, цаасны хаягдлыг цаас боловсруулах үйлдвэрт тушаах	-	Жилд 2 удаа	
	Гал тогооноос гарсан хоол, хүнсний хаягдлыг бордоо болгох	-	7 хоногт 1 удаа	
	Хөрс шатах тослох материалаар бохирдсон тохиолдолд бохирдсон хэсгийг ялган авч саармагжуулах	2.0	Тухай бүрд нь	
	Боломжтой хог хаягдлыг дахин ашиглах	-	Тухай бүрд нь	
Шатах тослох материалаар хөрс, газрын доорх ус бохирдож болзошгүй	Ажилласан тос, тосолгооны материалыг битүүмжлэл сайтай саванд хуримтлуулах	-	Жилд 2 удаа	
Ахуйн бохир шингэнээр хөрс бохирдоно	Ахуйн бохирыг био 00-өөр шийдэх	Хөрөнгө оруулалтын зардал	-	
Аюултай хог хаягдлын хадгалалтын горим алдагдсанаас орчны хөрс, ус, агаарыг бохирдуулах	Аюултай хог хаягдал тээвэрлэх, хадгалах, устгах үйл ажиллагаа эрхэлдэг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгж байгууллагатай гэрээ байгуулан эдгээр үйл ажиллагааг гүйцэтгэх.	-	Тухай бүрд нь	
Аюултай хог хаягдлаар хөрс, ус, агаар бохирдох, улмаар хүн амьтын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх				
Бохирдсон зүү тариур, боолтоор халдвар дамжих, тархах эрсдэлээс сэргийлэх	Эмнэлгийн хог хаягдлыг мэргэжлийн байгууллагаар устгуулах	Гэрээ байгуулах	Улиралд 1 удаа	

Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-009495 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Баянголын дэнжийн Б хэсэг”-ийн алтны шороон ордын 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Ажилчид санаатай болон санамсаргүйгээр ил задгай хог хаях	Уурхайн ажилчдад өөрсдийн үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдал, түүнийг хэрхэн ангилан ялгах, боломжтойг дахин ашиглах талаар сургалт явуулах	-	Жилд 1 удаа	
Бусад	Үлдэгдэл хог хаягдлыг эцэслэн зайлуулахдаа сумын ТҮК-тай гэрээ байгуулан зайлуулах	2.0	Жил бүр	
Ачуулсан хог хаягдал бүр дээр	Хог хаягдлын бүртгэл хөтлөх, зургаар баримтжуулах	-	Тухай бүрд нь	
Нэг жилийн зардал, сая.төг		7.5		

Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-009495 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Баянголын дэнжийн Б хэсэг”-ийн алтны шороон ордын 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Баянгол тариалан” ХХК -аас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь БОМТ-тэйгээ нягт уялдсан бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө. Байгаль орчны хяналт шинжилгээг 2026 онд байгаль орчны мэргэжлийн байгууллагаар хийлгэхээр төлөвлөсөн.


Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1	Агаар орчны бохирдол агаар дахь тоосны агууламж, NO ₂ , SO ₂ CO-ын агууламж, Хүнд металл тодорхойлох Агаар орчны бохирдол агаар дахь цацраг, дуу чимээ, агаарын харьцангуй чийгшил	Уурхай, Уурхайн ухаж ачих процессын үед, ажилчдын хотхон, уурхайн дотоод зам,	8-р сард	5 цэгт жилд 1 удаа хэмжилт хийлгэнэ. (нэг цэгт 20 минут, автомат анализатораар хэмжилт хийхээр тооцсон)	100000	500.0		MNS 4585:2016 MNS 6063:2010 MNS 6768:2019 MNS 3113:1981 MNS 5885:2008 Агаарын тухай хууль 2012.05.17 Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль 2010.06.24
2	Усны ерөнхий химийн шинжилгээ, бактериологийн шинжилгээ (рН, ЕС, TDS, нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ, рН, цахилгаан дамжуулах чанар, Cl, SO ₄ , NO ₂ , NO ₃ , CO ₃ , HCO ₃) Ахуйн хаягдал усны ерөнхий химийн шинжилгээ, бактериологийн шинжилгээ (рН, ЕС, TDS, нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ, рН, цахилгаан дамжуулах чанар) Цэвэр болон бохирын нуураас хүнд металлын шинжилгээ /As, U, Pb, W, Th, Sn, Nb, Se, Zn, Zr/	Худаг-Туул голын эх болон адаг	8-р сард	Усны ерөнхий химийн шинжилгээ Хими бактериологийн бүрэн шинжилгээ 1 цэгээс 2 удаа	Усны ерөнхий химийн шинжилгээ нэгжийн үнэ 75.0 мян.төг *5=375.0 мян.төг Хими бактериологийн бүрэн шинжилгээний үнэ 100.0*1/ундны усны худаг/ удаа=100.0 мян.төг Хүнд металлын шинжилгээний үнэ 60.0 мян.төг Знуур*1удаа*180.0 мян.төг	Нийт 655.0 мян.төг *монгол ус итгэмжлэгдсэн лабораторийн үнэ		MNS /ISO/ 5667-11:2000 MNS 6148:2010 MNS 4943:2015 MNS 0900:2018 Усны тухай хууль 2012.05.17

Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-009495 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Баянголын дэнжийн Б хэсэг”-ийн алтны шороон ордын 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

3	Хөрсний агрохими, нийт азот, хөдөлгөөнт фосфор, солилцох кали, карбонат, Хүнд металл(Cr, Pb, Cd, Ni, Zn), бактери	Уурхайн шимт хөрсний овоолго, ахуйн бохир усны хаягдал орчимд, хотхон, засварын талбай	8-р сард	4 цэгт 1 удаа	75000	300.0		MNS 5850 : 2019 MNS 3298 : 1991 MNS 5546 : 2005 MNS 3985 : 1987 MNS 2305 : 1995
4	Орд орчмын ургамлын бүрхэц, зүйлийн бүрдлийн судалгаа,	Тусгай зөвшөөрлийн талбай	2025 онд		-	1000.0		Байгалийн ургамлын тухай хууль 1995.04.11 Ургамал хамгааллыг тухай 2007.11.15
Нийт зардал мян.төг		2455.0						

Уурхайн мониторингийн байршлын цэг



Зураг 2. Мониторингийн байршлын зураг

Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-009495 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Баянголын дэнжийн Б хэсэг”-ийн алтны шороон ордын 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавьж ажиллана.

Хүснэгт 10. 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын ажлын зардал

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Усны нөөцийг үр ашигтай ашиглаагүйгээс газрын доорх усны нөөц, горимд өөрчлөлт орно.	Ус ашиглах дүгнэлт гаргуулан, холбогдох газраас ус ашиглах зөвшөөрөл авах	Гадаргын болон газар доорх усны нөөц	-	-	Усны тухай хууль
Ажилчдын мэдлэг чадвар дутмаг байдлаас ажлын доголдол гарах	Уурхайд ажиллаж байгаа ажиллагсдын тухайн ажлыг хийж гүйцэтгэх мэдлэг чадварыг сайжруулах зорилгоор мэргэжлийн сургаалтанд хамруулж байх	Жил бүр	2.0	Жил бүр	МУ-ын үндсэн хууль Хөдөлмөрийн тухай Эрүүл мэндийн тухай Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм
Байгаль орчны хууль тогтоомжийн өөрчлөлт, шинэлэг мэдээллээр ажилчдыг хангах	Нийт ажилчдад байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээлтийн чиглэлээр сургалт хийх	8-9 сард	-	2026	Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм MNS 4990:2000 MNS 4968:2000 MNS 4994:2000
Нийт зардал, сая.төг			2.0		

Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-009495 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Баянголын дэнжийн Б хэсэг”-ийн алтны шороон ордын 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ СУМ БАГИЙН ИРГЭДЭД ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХУВААРЬ

Хүснэгт 11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх арга хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Төслийн талбайн ойролцоох иргэд болон төсөл хэрэгжиж буй баг, сонирхогч талууд, засаг захиргааны ажилчид	Төслийн талаарх мэдээллийг цаасан болон presentation хэлбэрээр тайлагнах, хэлэлцэх	Төслийн нөөц, ашиглалтын техник технологи, ажилчид, бусад үйл ажиллагааны талаарх мэдээлэл, төслөөс байгаль орчин болон нийгэм эдийн засаг, хүний эрүүл мэндэд үзүүлсэн эерэг, сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах багасгах чиглэлээр хийсэн арга хэмжээ, байгаль хамгаалах, дүйцүүлэн хамгаалах чиглэлээр хийсэн, нөхөн сэргээлтийн ажлын тухай	Жилд 1 удаа. 10-11 сард.	Төслийн үйл ажиллагаагаар уурхайн ойролцоох малчдын амьдрал ахуй, эрүүл мэнд, нийгэмд үзүүлсэн эерэг, сөрөг нөлөө, сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах чиглэлээр хэрэгжүүлбэл зохистой арга хэмжээ, төслийн үйл ажиллагааны талаарх санал бодлыг сонсох	Багийн эсвэл сумын төв
Зардал, сая.төг					-

БОМТ-ний биелэлтийн тайланг тухайн оны 12 сарын 10-ний дотор БОУАӨЯаманд ирүүлэх ба үүнээс өмнө хуваарийн дагуу орон нутгийн иргэд, засаг захиргааны байгууллага, нутгийн оршин суугчид, сонирхогч талуудад танилцуулж хэлэлцүүлэн тэдний санал бодлыг тайланд тусгасан байна.

Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-009495 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Баянголын дэнжийн Б хэсэг”-ийн алтны шороон ордын 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн төсөв

Хүснэгт 12. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт

Д.д	Зардлын утга	Нийт зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	9500.0
2	Тэр бум мод үндэсний хөдөлгөөн ажлын зардал	6000.0
3	Нөхөн сэргээлтийн зардал	3000.0
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	10000.0
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	7500.0
5	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	1000.0
7	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2000.0
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2655.0
9	Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	1000.0
10	2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн	42655.0

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө нөхөн сэргээх арга хэмжээнд нийт **42.6 сая** төгрөг зарцуулахаар төлөвлөөд байна. Үүний 50 хувь 21.3 сая төгрөг байна.

2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр Туул голын газрын захиргаатай гэрээ байгуулсан боловч тухайн үеийн цаг агаарын хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас үйл ажиллагааг эхлүүлэх боломж бүрдээгүй иймд 2025 онд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.15 дахь заалтад зааснаар Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-04 тоот тушаалын дагуу Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулсан **21,800,000** төгрөгийг 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд шилжүүлэн тооцож өгөхийг хүсэж байна.